

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2025 оны 01 дүгээр сарын тайлан  
Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар**

2025.02.04

Шивээговь сум

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
5	11	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	2025 оны 01 дүгээр сарын байдлаар тус байгууллагад иргэдээс ирүүлсэн төрийн үйлчилгээтэй холбоотой болон бусад хууль ёсны асуудалтай холбоотой гомдол санал ирээгүй болно.	100		
11	17	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Цахим аймаг” арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд цахимаар мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор “Шивээговь сум мэдээ” цахим хаягаар 2025 оны 01 дүгээр сарын байдлаар нийт-49 мэдээлэл цацагдсанаас шинээр-22, бусад байгууллагын-27 мэдээлэлийг байршуулсан байна. Мөн веб сайтад сумын <a href="http://shiveegovi.gs.gov.mn/">www. http://shiveegovi.gs.gov.mn/</a> цахим хуудсанд цаг үеийн болоод мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуух холбоотой нийт-13 мэдээ мэдээллийг байршуулсан байна. 2025 оны 01 дүгээр сарын байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт 4900 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан, бусад зар мэдээллийн 8 рүүгдэд дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Мөн иргэдэд өөртөө үйлчлэх нөхцөлийг бүрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор 2025 оны 1 дүгээр сард	100		

				24/7 гэрэгэ киоск машиныг ЗДТГ-т байршуулсан байна. Үр дүн: 2025 оны 01 дүгээр сарын байдлаар “ХУР ДАН” системээр иргэдэд үзүүлсэн үйлчилгээний тоо:43			
25	33	Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449	3.. 3.Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгасугай.	2025 оны 01 дүгээр сард сумын малчдад улсын нөөцөөс өвс тэжээл хуваарьлаж, тараагдаагүй байна.	-		
27	37	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483	2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	2025 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд орон сууц барих ажил тусгагдаагүй бөгөөд суманд нийт 12 орон сууц байдаг бөгөөд сумын 4000 орчим иргэнд хүрэлцээтэй байна.	-		

32	46	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	Төрийн үйлчилгээг иргэн, байгууллагад цахим хэлбэрээр түргэн шуурхай хүргэх зорилгоор E-Монголиа системийн операторын тоон гарын үсэг токен төхөөрөмжөө 2025 оны 01 дүгээр сард 2 жилийн хугацаатай сэргээж E-mongolia системийн үйл ажиллагааг иргэдэд тэгш хүртээмжтэй түргэн шуурхай хүргэх боломж бүрдэж хэвийн ажиллагаанд орсон байна. 2025 оны 01-р сарын 02-ноос 02-р сарын 04-ний хооронд нийт 43 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Мөн иргэдэд өөртөө үйлчлэх нөхцөлийг бүрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зориолгоор 2025 оны 1 сард 24/7 гэрэгэ киоск машиныг ЗДТГ-т байршуулсан байна. Гэрэгэ Киоск төхөөрөмж нь 60 гаруй байгууллагын 600 орчим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн иргэд, олон нийтэд үйлчилгээг үзүүлж байна. <b>Үр дүн:</b> Цахим хэлбэрээр шинээр байршсан төхөөрөмжийн тоо-1	100		
41	56	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187	4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай	Малчдын хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор 1 байршлыг 2025 оны тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган сумын ИТХ-н 2024 оны 12 сарын 04-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор батлуулсан байна. Төлөвлөгөөний дагуу 2025 оны эхний хагас жилд багтаан төсөл сонгон шалгаруулалтыг зарлан шалгаруулж олгохоор төлөвлөөд байна. <b>Үр дүн:</b> Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан.	100		

			бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай			
42	57	Ариун цэврийн байгуулам бүхий түр буудаллах цаг, үйлчилгэний цогцолбор барьж байгуулах тухай 2024-05-01 Дугаар 2024_189	2.. Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд эзэмшүүлэх газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний 189 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан сумын 2-р багийн нутаг дэвсгэрийн улсын чанартай босоо тэнхлэгийн авто замын зүүн талд байрлах 19994м2 газрыг Олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замын тээврийн хэрэгслийн түр зогсоолын талбайгаар төлөвлөн 2025 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 04 дугаар тогтоолоор батлуулсан байна. Тогтоолын дагуу 2025 онд Засаг даргын Тамгын газрын нэр дээр сумын Засаг даргын захирамжаар олгохоор төлөвлөөд байна. <b>Үр дүн:</b> Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийг төлөвлөгөөнд тусган батлуулсан.	100	
	59		4.. Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн цэвэрлэгээ, арчлалт, хог хаягдлын асуудлыг зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай	Сумын төвөөс 10 км, аймгийн төвөөс 35 км орчмын зайд Зуумайн ухаа гэх газрын ойролцоох улсын чанартай босоо тэнхлэгийн автозамын зүүн талд 1 түр буудаллах цэг байдаг бөгөөд тус түр буудаллах цэгт ариун цэврийн нойл, хог хаях хогийн сав зэргийг байрлуулан ажиллаж байна. Тус цэгийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан арчилгаа хамгаалалт болон хог хаягдлын асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд урин дулааны үе болон амралт зугаалга ихтэй саруудад 7 болон 14 хоногт, бусад саруудад сар болгон тогтмол хог хаягдлыг ачиж цэвэрлэдэг. Мөн сумын хэмжээнд 1 отоглох цэг байдаг бөгөөд байршил нь Хаялага нууранд байрладаг. Тус отоглох цэгт 3 хогийн сав, 2 хогийн цэг, 2 ариун цэврийн нойл,	100	

				<p>амралтын шовгор байшингуудыг байрлуулсан байна. Тус цэгийн хог хаягдлын асуудлыг сумын ЗДТГ болон “Шивээ-Овоо” ХК тогтмол шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p><b>Үр дүн:</b> 01 дүгээр сарын байдлаар хог хаягдлыг цэвэрлэсэн тоо-1 Амралт зугаалгын зөвшөөрөгдөх бүс, отоглох, түр цэгийн тоо-2</p> <p>Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ- 2.5 тн</p>			
43	59	<p>Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196</p>	<p>3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай</p>	<p>Хүний нөөцийн цахим системд сумын төсвийн 6 байгууллага төрийн албан хаагчдын мэдээллийг 100% оруулан ажиллаж байна.</p>	100		
44	61	<p>Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215</p>	<p>4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Оосх)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын</p>	<p>Тус байгууллага төрийн болон албаны нууцад хамаарах бичиг баримтыг илгээх, хүлээн авахдаа ERP системийг ашигладаг бөгөөд (Оосх) системийг хэрэглэж эхлээгүй байна. ЗДТГ-т 2025 оны 01-р сарын 31-ний өдрийн байдлаар 81 албан бичиг ирснээс ERP системээр 47 албан бичгийг хүлээн авч бүртгэл хөтлөн удирдлагад танилцуулж, шийдвэрлэн ажилласан. ЗДТГ-аас гадагшаа, бусад албан байгууллагууд руу 78 албан бичгийг явуулснаас цахим системээр 21 албан бичгийг илгээсэн байна.</p>	70		

			удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.				
53	76	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ танилт, нэвтрэлтийн систем болох тоон гарын үсэг, иргэний үнэмлэх, хурууны хээ болон иргэний өөрийн бүртгэлтэй утасны дугаарт код илгээж төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажиллаж байна.	100		
55	78	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024-12-25 Дугаар 2024_238_1	2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тус тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 дугаар “Төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай” захирамж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/43 дугаар “Төрийн албан хаагчдын цалинг шинэчлэн батлах тухай” захирамж, Шивээговь сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/43 дугаар “Сумын засаг даргын Тамгын газрын орон тоо, цалин санг батлах тухай” захирамж, 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/20 дугаар “Төрийн албан хаагчдын цалинг шинэчлэн батлах тухай” захирамж, ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/01 дугаар “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тоо, цалин сан нэмэгдлийг шинэчлэн батлах тухай” тушаалыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.	100		
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
34	46	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	ХХ0 авч, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага,	Сумын хэмжээнд нийт тоон гарын үсэг авах 16-91 насны 2405 иргэн байгаа бөгөөд үүнээс 2022 онд 1275 иргэн, 2023 онд 167 иргэн, 2024 онд 120 иргэн, 2025 оны 01 дүгээр сард 3 иргэнд олгож, нийт өссөн дүнгээр 1565 иргэнд олгосон байна.	70		

		2022-05-11 Дугаар 2022_28	төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	<b>Үр дүн:</b> Нийт тоон гарын үсэг авах иргэдийн 65.07 хувь нь тоон гарын үсэг буюу цахим гарын үсэгтэй болсон байна.			
63	86	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Төрийн үйл ажиллагааны дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. ЗДТГ-т 2025 оны 01-р сарын 31-ний өдрийн байдлаар ERP системээр 47 албан бичгийг хүлээн авч бүртгэл хөтлөн удирдлагад танилцуулж, шийдвэрлэн ажилласан. ЗДТГ-аас гадагшаа, бусад албан байгууллагууд руу цахим системээр 21 албан бичгийг илгээсэн байна.	100		
42	55	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн	Манай байгууллагаас Үндэсний судалгааны нэгдсэн сан болох <a href="http://www.sudalгаа.gov.mn">www.sudalгаа.gov.mn</a> цахим платформд байршуулах 2025 оны 01 дүгээр сарын байдлаар төрийн байгууллагын захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил байхгүй болно.	-		

			оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;			
48	62	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Улсын онцгой байдлын ерөнхий газар болон аймгийн Онцгой байдлын газрын Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг сумын “Шивээговь сум мэдээ” цахим хаягаар анхааруулга, сэрэмжлүүлэгийг олон нийтэд тогтмол мэдээллэн хүргэж ажиллаж байна. <b>Үр дүн:</b> 01 дүгээр сарын байдлаар Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх 8 мэдээллийг иргэдэд хүргэсэн байна.	100	
51	65	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг	2025 оны 1 дүгээр улирлын тайланг байршуулах мэдэгдэл ирсний дагуу мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д хугацаандаа байршуулахаар төлөвлөн мэдээллийг байршуулан ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу сумын хэмээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн 6 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. <b>Үр дүн:</b> 2025 оны 01 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 100 хувьтай, байршуулвал зохих 111 мэдээллийг ил тод мэдээллэсэн байна.	100	



			<p>нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах;</p> <p>2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах;</p> <p>3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.</p>				
74	98	<p>2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25</p>	<p>XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,</p>	<p>Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд иргэдэд мэдээ мэдээллийг цахим хаягаар дамжуулан шэйрлэн иргэд олон нийтэд хүргэж ажиллаж байна.</p> <p><b>Үр дүн:</b> Мэдээллэсэн мэдээллийн тоо-6</p>	100		
	100		<p>XIII.10.. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил,</p>	<p>Цахим аймаг” арга хэмжээний хүрээнд сумын хэмжээнд цахимаар мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор “Шивээговь сум мэдээ” цахим хаягаар 2025 оны 01 дүгээр сарын байдлаар нийт-49 мэдээлэл цацагдсанаас шинээр-22, бусад байгууллагын-27 мэдээлэлийг байршуулсан байна. Мөн веб сайтад сумын <a href="http://shiveegovi.gs.gov.mn/">www. http://shiveegovi.gs.gov.mn/</a> цахим хуудсанд цаг үеийн болоод мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуух холбоотой нийт-13 мэдээ мэдээллийг байршуулсан байна. 2025 оны 01 дүгээр сарын байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт 4900 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр,</p>	100		

			харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан, бусад зар мэдээллийн 8 группэд дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна. Мөн иргэдэд өөртөө үйлчлэх нөхцөлийг бүрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор 2025 оны 1 дүгээр сард 24/7 гэрэгэ киоск машиныг ЗДТГ-т байршуулсан байна. <b>Үр дүн:</b> 2025 оны 01 дүгээр сарын байдлаар “ХУР ДАН” системээр иргэдэд үзүүлсэн үйлчилгээний тоо:43			
81	122	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	20.11.1 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажлын хүрээнд сумын албан ёсны вэб сайтыг нэгдүгээр улиралд багтаан шинэчлэх ажлыг төлөвлөн, тус ажлыг эрчимжүүлэн вэб сайтаа шинэчлэх ажил хийгдэн мэдээ мэдээллийг цаг тухай бүр байршуулан мэдээллийг шуурхай, хариуцлагатай, хүргэн ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан заалтын дагуу мэдээллүүдээ тухай бүр шинэчлэн холбогдох мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна. <a href="http://www.shiveegovi.gs.gov.mn/">http://www.shiveegovi.gs.gov.mn/</a> <b>Үр дүн:</b> “Шивээговь сум мэдээ” цахим хаягаар нийт-49 мэдээлэл цацагдсанаас шинээр-22, бусад байгууллагын-27 мэдээллийг байршуулсан байна 2025 оны 01 дүгээр сарын байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт- 4900 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан, бусад зар мэдээллийн 8 группэд дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.	100		
95	136	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31	31.9.6. 2/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд	Сумын <a href="http://shiveegovi.gs.gov.mn/">www.http://shiveegovi.gs.gov.mn/</a> цахим хуудсанд цаг үеийн болоод мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуух холбоотой нийт-13 мэдээ мэдээллийг байршуулсан байна. 2025 он	100		

		дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31	дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	гарснаар нийт төрийн байгууллагын веб сайт нэгтгэгдэх ажил хийгдэж байна.			
101	144	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэл 2024-12-30 Дугаар 2024_47	47.8.1.2. Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд бэлэн байдалд ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов.	Тус шийдвэр гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар 03-ны өдрийн А/143 дугаар "Сумын шуурхай штаб байгуулах тухай" захирамжаар сумын шуурхай штаб байгуулагдаж, 24 цагаар тасралтгүй ажиллах хуваарийг хавсралтаар батлан, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байна.	100		
<b>ЗГ-ын албан даалгавар</b>							
62	89	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Орон нутагт шаардлагатай мэргэжлээр шилжиж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, бусад албан хаагчдыг ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдэж, түрээслэгчийн сонгон шалгаруулалтын зар мэдээллийг сумын цахим хаягт байршуулан ажиллаж байна. Тус сонгон шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сард зарлаж, шалгаруулахаар ажиллаж байна. <b>Үр дүн:</b> Түрээсийн орон сууцны байрны тоо-1	100		

		салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;				
<b>Дундаж биелэлт</b>						<b>97</b>

			Бүгд	Үүнээс		
				Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо			<b>21</b>	<b>11</b>	<b>9</b>	<b>1</b>
Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо			<b>23</b>	<b>12</b>	<b>10</b>	<b>1</b>
Хэрэгжилтийн үнэлгээ	Бүрэн хэрэгжсэн	100%	<b>18</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>1</b>
	Хэрэгжих шатанд	70 %	<b>2</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>
	Хэрэгжилт хангалтгүй	30 %	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
	Хэрэгжээгүй	0 %	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй			<b>3</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Биелэлтийн хувь</b>			<b>97</b>	<b>97</b>	<b>96.6</b>	<b>100</b>

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА